

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн хэрэгжилтийн талаарх Завхан аймгийн үйл ажиллагааны тайлан

АУДИТЫН КОД: АДГ-2022/18-ШТА-ГА

Улиастай сум 2022 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа

Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Б.Дагвасүрэн

Утас: 7046-3783, Цахим хаяг: Dagvasureng@audit.gov.mn

Гэрээт ажилтан Т.Баасанжаргал

Утас: 92012266, Цахим хаяг: Baasanjargalt@audit.gov.mn

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
ХОЁР. ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ	3
ГУРАВ. ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	7
ДӨРӨВ. ШУУРХАЙ ШТАБЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	8
ТАВ. ИРГЭДИЙГ ТАТАН АВАХ, ТУСГААРЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	8
ЗУРГАА. ТАНДАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	8
ДОЛОО. ДАРХЛААЖУУЛАЛТ	10
НАЙМ. НӨӨЦ ХАНГАЛТ	11
<u>ЕС</u> . ЦААШИД ӨВЧЛӨЛ НЭМЭГДЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ:	14

ТОВЧИЛСОН ҮГ:

ОБГ - Онцгой байдлын газар

МХГ - Мэргэжлийн хяналтын газар

ЭМГ - Эрүүл мэндийн газар

ЗДТГ-Засаг даргын тамгын газар

ЗӨСТ -Зооноз өвчин судлалын төв

УАУ - Уламжлалт анагаах ухаан

ХӨСҮТ – Халдварт өвчин судлалын үндэсний төв

АНЭ – Аймгийн нэгдсэн эмнэлэг

НҮБ – Нэгдсэн үндэсний байгууллага

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Завхан аймгийн Шилүүстэй суманд 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр анх Коронавируст халдварын тохиолдол бүртгэгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 12073 тохиолдол батлагдаж үүнээс 11990 тохиолдол эдгэрч, 19 тохиолдол нас барсан байна. Сумдын Эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн, Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэгт 926 тохиолдлыг шилжүүлэн эмчилсэн байна.

№	Сумын нэр	Нийт халдвар тоо /сумаар/	Нийт эдгэрэлт	Нас баралт
	Нийт дүн	12073	11990	19
1	Улиастай	5317	5917	15
2	Алдархаан	289	245	
3	Асгат	94	89	
4	Баянтэс	278	220	
5	Баянхайрхан	107	79	
6	Дөрвөлжин	505	502	
7	Тосонцэнгэл	1459	1708	3
8	Завханмандал	163	114	
9	Идэр	420	347	
10	Нөмрөг	239	211	
11	Их-Уул	796	727	
12	Сонгино	173	122	
13	Сантмаргац	188	176	
14	Отгон	176	133	1
15	Түдэвтэй	127	110	
16	Тэс	197	163	
17	Тэлмэн	314	210	
18	Ургамал	313	284	
19	Цагаанхайрхан	85	82	
20	Цагаанчулуут	150	94	
21	Цэцэн-уул	184	139	
22	Шилүүстэй	328	287	
23	Эрдэнэхайрхан	74	56	
24	Яруу	97	75	

ХОЁР. ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Шилүүстэй суманд 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Коронавируст халдварын анхны тохиолдол бүртгэгдэж, Монголд анх удаа суманд батлагдсан

тохиолдлыг ХӨСҮТ-ийн эмч нар болон Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдан ажилласан салбар хоорондын хамтарсан баг хамт олон ажиллаж голомтын цар хүрээг тогтоож, эмчилгээний стандартын дагуу эмчилсэн байна.



Коронавирус халдварын цар тахлын эхэн үед аймгийн хэмжээнд 9 суманд батлагдсан тохиолдол бүртгэгдэж хариу арга хэмжээг түргэн шуурхай авахын тулд ЭМГ, Тагнуулын хэлтэс, АНЭ, ЗӨСТ, МХГ, ОБГ-ын мэргэжилтнүүдээс бүрдсэн баг бүрэлдэхүүн тухай бүр Тосонцэнгэл, Их-уул, Шилүүстэй, Завханмандал, Дөрвөлжин, Цэцэн-уул, Сонгино, Алдархаан, Отгон суманд ажиллаж халдварын нөхцөл байдалд үнэлгээ хийж хариу арга хэмжээг цаг алдалгүй авч, эрсдэлийн багын хийсэн эрсдэлийн үнэлгээний дүнг үндэслэн 6 удаагийн тодотгол ажилласан байна.



Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 тоот тушаалаар баталсан Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу эрсдэлийн үнэлгээг аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/89 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 7 удаа хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг тухай бүр боловсруулан гарган ажилласан. Хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулахын тулд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Монгол улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын 7 хоногийн мэдээнд

тулгуурлан аймгийн хэмжээнд ямар түвшинд байгааг харьцуулан дүгнэлт хийж дээд шатны байгууллагуудад саналаа хүргүүлжээ. Мөн гэрийн тусгаарлалтын талаар цахим судалгааг “Google forms” ашиглан нийт 3 удаа авсан. Судалгаанд нийт 178 хэрэглэгч оролцсон байна.

НҮБ-ын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “КОВИД-19 цар тахлын үед хүүхэд асран хамгаалагчдад нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх” төслийг Завхан аймгийн Улаан загалмайн хороотой хамтран хэрэгжүүлж, цар тахлаар өвчилсөн 100 хүүхэд, 467 гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлжээ.



Явуулын 5 цэгт 75 хүний бүрэлдэхүүнтэй массын шинжилгээ авах тандалтын баг ажилласан, Коронавируст халдварын цар тахлын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор ЭМЯ-аас АНЭ-т МА-6000 маркийн ПСР шинжилгээний аппарат, Хятад улсад үйлдвэрлэсэн Sansure biotech маркийн нүклеин хүчил ялгагч аппарат нийлүүлэгдэж орон нутагт молекул биологийн лабораторийг байгуулсан.

Идэвхтэй тандалтад давхардсан тоогоор 82514 иргэнийг хамруулж түргэвчилсэн шинжилгээнд 49227 иргэн хамруулсны 19.2 хувь, ПГУ-ын шинжилгээнд 33287 иргэн хамруулсны 17.8 хувь коронавируст халдвараар өвчилсөн байна.

Дүн шинжилгээг долоо хоног тутмаар нь нэгтгэн гаргаж Аймгийн шуурхай штабыг мэдээллээр хангаж ажилласан байна.

КОВИД-19 илрүүлэх лабораторийн шинжилгээнд эерэг эзлэх хувь /сараар/



Яаралтай тусламжийн гадна талбайд хэвтэн эмчлүүлэгч иргэдээс түргэвчилсэн тестээр шинжилгээ авах цэг гаргасан.



“Түр ор дэлгэх тухай” ЭМС-н А/587, А/460 тушаалын дагуу Дельта хувилбарын дэгдэлтийн үед МУИС-ийн харьяа Эдийн засгийн сургуулийн оюутны дотуур байранд 100 ор, Биеийн тамир спортын газрын спорт зааланд 100 ор, Политехник коллежийн байранд 100 ор, Ерөнхий боловсролын III-р сургуулийн байранд 100 ор, Уламжлалт анагаах ухааны төвд 50 ор, “Одчим наран” эмнэлэгт 50 ор, Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын II-р сургуулийн дотуур байранд 100 ортой эмнэлэг дэлгэн нийт **3000** гаруй тохиолдлыг эмчилсэн.



Ковид-19 халдвар бүртгэгдсэн сумуудад ЭМГ, ЗӨСТ, АНЭ, МХГ болон бусад эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл ахуйч, халдвар судлагч, их эмч нараар ахлуулсан халдваргүйжүүлэлтийн багууд ажиллаж батлагдсан тохиолдлын ажлын газар, үйлчлүүлсэн байгууллага, гэр, орон сууц, орц гэх мэт 3684 объектийн 675254.5 мкв талбайд 0.06%-ийн жавелион, гипохлорит кальци, 2%-ийн содийн

уусмал ашиглан халдваргүйжүүлэлт хийсэн. Нийтийн эзэмшлийн **406655мкв** талбайд хлор агуулсан бодисоор халдваргүйжүүлэлт хийсэн.



Сумын ЭМТөвүүд халдвартай хог хаягдлыг түр хадгалах байранд түр хадгалж, сумын төвийн хогийн цэгт тусгай цэг гарган шатааж устгадаг болсон. Нийт 19200 кг хог хаягдал гарч устгасан.

ГУРАВ. ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2020-2021 онд Орон нутагт гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хор уршгийг арилгах зорилгоор аймгийн Онцгой комиссын хурлыг 63, Нэгдсэн шуурхай штабын хурлыг 78 удаа зохион байгуулж 647 шийдвэр гарган холбогдох арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна.

Шийдвэртэй холбогдуулан гаргасан эрх зүйн баримт бичиг: Засаг даргын албан даалгавар 10, Захирамж 128, Тогтоол 1, түр журам 15, мэдэгдэл 1, албан бичиг 340, төлөвлөгөө 20-ыг боловсруулан холбогдох газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллажээ.

- Агаарын тээврээр 5588 хүн, нийтийн тээврээр 68033 хүн, эрүүл мэндийн асуумж хуудас бөглөсөн 18463, нийт 73621 иргэнд угтах зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.

- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний судалгааг 7 хоног бүрийн Даваа, Пүрэв гарагт сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-д хүргүүлэн ажиллаж. Мөн шатах тослох материалын нөөцийг 7 хоног бүрийн Даваа гарагт авч нөөц хангалт хийх ШТС-д зөвшөөрөл олгон, татан авалт хийжээ.

2021 оны 1-4 сард 506 тээврийн хэрэгслээр татан авалт хийсэн.

Аймгийн Засаг даргын санаачилгаар хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хяналт тавих Засаг даргын орлогчоор ахлуулсан “Ажлын хэсэг” байгуулагдан дараах ажлыг зохион байгуулсан.



Гурил: Иргэдэд үйлдвэрийн үнээр гурил хүргэх ажлыг зохион байгуулж 18 суманд 490 тн гурил 1-р гурил 25кг 28500 төг, 50 кг нь 58,000 төгрөгийн үнээр;

Будаа: Улиастай сумын 1200 өрхөд цагаан будааг 1 кг нь 1,680 төгрөгөөр буюу УБ хотын бөөний үнээр, нийт 30 тн цагаан будааг хүргэж ажилласан байна.

Мах: 1 кг махыг 9000 төгрөг, 1 хонийг 200,000 төгрөгөөс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авч ажиллалаа. 400 хонь буюу 8,8 тн, 46 үхэр буюу 9,2 тн, нийт 18 тн махыг Улиастай сумын айл өрхүүд худалдан авсан байна.

ДӨРӨВ. ШУУРХАЙ ШТАБЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 22 дугаар тушаал, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн орон нутгийн шуурхай штаб, шуурхай хариу арга хэмжээний багуудыг аймгийн Засаг даргын 2021 оны А/141 дүгээр захирамжаар 7 баг, 10-н бүлэгтэйгээр шинэчлэн байгуулсан. Мөн аймгийн Засаг даргын 2021 оны А/256, А/409 дүгээр захирамжуудаар аймгийн Онцгой комиссын нэгдсэн шуурхай штабын бүтэц, бүрэлдэхүүнд 5 тодотгол, боловсруулалт хийж ажилласан. Аймгийн шуурхай штабын бүтэц схемийг Хавсралт-1-ээр харуулав

ТАВ. ИРГЭДИЙГ ТАТАН АВАХ, ТУСГААРЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын онцгой комиссын 2020 оны 330 дугаар албан бичиг, УОК-ын 80 дугаар тушаалын дагуу “Гэрийн тусгаарлалт, ажиглалтад иргэдийг шилжүүлэн хяналтыг зохицуулах түр журам”, аймгийн Засаг даргын А/111 дүгээр захирамжийн дагуу МХГ-ын даргаар ахлуулсан татан авалтын бүлэг сумдад 210 тусгаарлах ор, Улиастай сумын 9 байранд 164 өрөө, 164 тусгаарлан ажиглах орны бэлтгэл ажлыг хангуулан ажиллажээ.

Татан авалтын ажиллагаагаар агаарын болон нийтийн тээврээр 3572, хувийн тээврийн хэрэгслээр 3300 зорчигч хүлээн авч тандалтаар 5065 иргэнийг гэрийн тусгаарлалтад 7-14 хоног тусгаарлах ажлыг зохион байгуулан хяналт тавьж ажилласан байна.

ЗУРГАА. ТАНДАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрүүл мэндийн газрын тандалтын өргөтгөсөн багын гишүүд Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/456 дугаар тушаалын дагуу батлагдсан тохиолдол болон түүний ойрын хавьтлын мэдээллийг цуглуулж, Google sheet ашиглан ХӨСҮТ-рүү мэдээллийг дамжуулан ажилласан. Цуглуулсан мэдээлэлд тухай бүр тандалтын баг дүн шинжилгээ хийж, холбогдох дээд шатны байгууллага, шуурхай штаб, Тагнуулын хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, УОК, Эрүүл мэндийн яаманд өдөр бүр 20:00 цагт хүргүүлэн ажилласан байна.

/2021.03.01-2021.12.31/



Дельта хувилбарын үед Эрүүл мэндийн газрын даргын өргөжүүлсэн тандалтын баг 24 сумд батлагдсан 12073 тохиолдлын тандалт судалгаа хийж ойрын болон дам хавьтал 38785 гаруй иргэнийг тогтоож гэрийн тусгаарлалтын дэглэмийг мөрдүүлэн хяналт тавьсан.

Коронавируст халдварын үед Khynalt.za.gov.mn бүртгэлийн программд 12939 батлагдсан болон ойрын хавьтлын мэдээлэл оруулж Цагдаагийн газар, ЗДТГ, МХГ-тай хамтран ойрын хавьтлын иргэд гэрээс гарах, бусдад халдвар тараахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

[illegible]

Аймгийн засаг даргын 2020 оны А/442 дугаар захирамжаар “Гэрийн тусгаарлан ажиглалтад байгаа иргэдэд хяналт тавих” ажлын хэсэг байгуулагдан төрийн байгууллагуудын 1119 /*давхардсан тоогоор*/ ажилтан албан хаагчдыг уг арга хэмжээнд татан оролцуулж, гэрийн тусгаарлан ажиглалтад байгаа 2082 иргэнд нийт 3548 удаа байнгын хяналт тавин ажилласан. Хяналтын явцад гэрийн тусгаарлан ажиглах журмыг зөрчсөн 85 иргэнд сэрэмжлүүлэг, зөвлөмж өгчээ.

Монгол улсад Коронавируст халдвар бүртгэгдсэн өдрөөс Аймгийн хэмжээнд “Угтах-Зөвлөх үйлчилгээг” хэрэгжүүлж Улаанбаатар-Доной чиглэлийн нислэгээр ирсэн 5588 иргэн, Нийтийн тээврээр ирсэн болон явсан 68033 иргэнд эрүүл мэндийн асуумжийн хуудас, халуун үзэх үйлчилгээг үзүүлж халуурсан 13 иргэн, Сүүлийн 14-21 хоног гадаад улс оронд аялсан 105 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч гэрийн хяналтын дэглэм мөрдүүлэн ажиллажээ.




ДОЛОО. ДАРХЛААЖУУЛАЛТ

Хүн ам олноор суурьшсан Улиастай сумын 6 баг, Тосонцэнгэл сумын 6, Их-Уул сумын 6 нийт 31796 суурин хүн ам бүхий томоохон 3 сумын 18 багаар тойрч дархлаажуулалтын зөвлөгөө мэдээллийг явуулын үзэлээр зар түгээж байгуулан гарын авлага, тараах материал, брошур зэргийг тараан иргэдийг вакциндаа идэвхтэй хамрагдахыг уриалан ажилласан.

Дархлаажуулалтын байнгын цэг Улиастайд 2 цэг, Сумдад 24 цэг нийт 26 цэг ажиллажээ.

Аймгийн хэмжээнд Коронавирусийн эсрэг дархлаажуулалтын 1-р тунд 48629 буюу 89.0%, 2-р тунд 47102 буюу 86.2%, дархлаа сэргээх 3-р тунд 21190 буюу 54.6 %-тай хамрагдсан.





Нэмэлт хүснэгт: Дархлаажуулалтын вакцины төрөл

Д/д	Вакцины нэр	Вакцинд хамрагдсан хүний тоо	Хувь
1	Вероцелл	78762	64.73
2	Фпайзер	42897	35.26
3	Астразенека	2	0.002
4	Спутник	3	0.002
5	Нийт	121664	100

НАЙМ. НӨӨЦ ХАНГАЛТ

-Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496, А/585 дугаар тушаалаар Коронавируст халдвар(ковид-19)-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын 995 албан хаагчдад 1375.6 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгогдсон.

-ЭМС-н 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/248 тоот тушаалаар санхүүжигдсэн 69214.1 мянган төгрөгийн санхүүжилтийг Шилүүстэй, Тосонцэнгэл, Их-Уул суманд ажилласан мэргэжлийн багийн 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд, Эрүүл мэндийн тухай хуулийн 30.2 дахь заалтын дагуу урамшуулалт цалинг ЭМГ-н даргын тушаалын дагуу олгосон.

КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар Аймгийн нэгдсэн эмнэлэгт Амьсгалын аппарат-4, Хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн баллон, редукторын хамт-5, Био аюулгүйн шүүгээ-1, Центрифуг-2, Хяналтын монитор-6, хүчилтөрөгч өтгөрүүлэгч-3, Унтуулгын аппарат-2, ПГУ-ийн машин-1, Автоклав-1 нийт 18 нэр төрлийн 386.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэгт Амьсгалын аппарат-3, Хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн баллон, редукторын хамт-2, Хагалгааны хажуугийн гэрэл-1, Деализийн аппарат-2 нийт 7 нэр төрлийн 235.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 13 нэр төрлийн 32147.4 мянган төгрөгийн эх, нярай эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ үзүүлэх багаж тоног төхөөрөмжийг ЭМС-ын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/713 тушаалаар нийлүүлсэн.

Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар нийт 105.9 сая эмнэлгийн тоног төхөөрөмжийг аймаг сумдад нийлүүлж, Аймгийн нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийн гадна дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд 11.0 сая төгрөг шийдвэрлэж өгсөн.

Азийн хөгжлийн банкны хандив тусламжаар Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэг, Түдэвтэй, Завханмандал сумдын сум дундын эмнэлэг, Цэцэн-Уул, Отгон, Цагаанхайрхан, Идэр сумын эрүүл мэндийн төвүүдэд нийт 6 нэр төрлийн 6.3 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэгдсэн.

НҮБХСангийн хандив тусламжаар Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нярайн амьсгалын аппарат, пульсоксиметр датчиктай М800, өвчтөний хяналтын монитор, тарианы автомат шахуурга нэмэлт хэрэгслийн хамт, Шилүүстэй сумын сум дундын эмнэлэг, Их-Уул сумын эрүүл мэндийн төвд Автоклав 50л, Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэгт дуслын автомат шахуурга нэмэлт хэрэгслийн хамт, нийт 6 нэр төрлийн 111.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.

АНУ-ын хандив тусламжаар Аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт инкубатор, Уушигны эерэг даралт үүсгэгч аппарат, фото шарлагийн аппарат, хэт авиан оношлогооны аппарат, Хяналтын монитор, хүчилтөрөгч өтгөрүүлэгч нийт 8 нэр төрлийн 143.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.



Улсын төсвийн санхүүжилтээр 500 сая төгрөгийн хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр баригдаж Коронавируст халдварын дельта хувилбарын үед АНЭ-ийн хэвтэн эмчлүүлэгч болон 23 сумын эрүүл мэндийн байгууллагуудад нэн хэрэгтэй

бүтээн байгуулалт хийгдсэн. Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр байгуулагдсанаар 23 сумын эрүүл мэндийн байгууллага болон аймгийн нэгдсэн эмнэлэг хүчилтөрөгчийн хомсдол үүсэхгүй иргэдэд тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэжээ.



Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хоорондын байгуулсан гэрээний дагуу ЭМСХХ-5 төслийн хүрээнд хийгдэх Аймгийн нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийн засварын ажил 367.6 сая төгрөгөөр хийгдэж 2021 оны 10-р сард хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 297 дугаар тогтоолоор “Улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх тухай” тушаалаар Онцгой байдлын газарт ковш, ус тээвэрлэгч, Тосонцэнгэл сумын Онцгой байдлын байдлын хэлтэст УАЗ пургон автомашин, Алдархаан, Тэс, Нөмрөг сумдын эрүүл мэндийн төв, Отгон сумдын Засаг даргын Тамгын газарт тус тус УАЗ пургон автомашин, Идэр сумын Засаг



даргын УАЗ 469 автомашин нийт 8 автомашин, техник олгож сум, орон нутгийн чадавхыг сайжруулжээ. Орон нутгийн хөгжлийн сангаас ЗӨСТ-1, Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэг-1, Аймгийн нэгдсэн эмнэлэгт-2 тусгай тоногдсон суудлын машин, бусад хандив тусламжаар Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэгт УАЗ-22069 маркийн Фургон машин-1, Дөрвөлжин сумын эмнэлэгт ниссан корован маркийн-1,

Сантмаргаз эмнэлэгт суудлын машин-1 нийт 3 машин нийт 310.0 сая төгрөгийн 10 машинд 178.8 сая төгрөгийн парк шинэчлэл хийсэн.

НҮБХСангийн хандиваар Түдэвтэй, Шилүүстэй СДЭ-ийн Эрүүл мэндийн төвүүдийн УАЗ пургон автомашиныг 60.0 сая төгрөгийн зөөврийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглосон.

Эрүүл мэндийн яамнаас 9 удаагийн татан авалтаар 660.8 сая төгрөгийн 16 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, Аймгийн засаг даргын тамгын газраас 48 сая төгрөгийн хувийн хамгаалах хэрэгсэл, Эрүүл мэндийн яамнаас 4 удаагийн татан авалтаар 115.3 сая төгрөгийн түргэвчилсэн оношлуур, 2.1 сая төгрөгийн шүлсний оношлуур, 60 ширхэг Gen Xpert оношлуур, Аймгийн Засаг даргын тамгын газраас 30 сая төгрөгийн түргэвчилсэн оношлуурыг хүлээн авч аймаг, сумдын эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан олгосон байна.

Судалгаанаас дүгнэхэд:

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд 2020 онд улс, орон нутгийн төсөв, албан байгууллага, ард иргэдийн хандиваар 136.9 сая төгрөг, эм, эмнэлгийн хамгаалах хэрэгсэл, эд хөрөнгийн 97.5 сая төгрөгийн нийт 234.5 сая төгрөгийн санхүүжилт төвлөрүүлж 194.3 сая төгрөгийг зарцуулсан.

- 2021 онд улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, албан байгууллага, ард иргэдийн хандиваар 10,446.2 сая төгрөг, 9,320.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хамгаалах хэрэгсэл нийт 19,777.0 сая төгрөгийг төвлөрүүлж 18,707.7 сая төгрөгийг зарцуулсан.
- Судалгаагаар 2021 оны 12 дугаар сарын 31-ээр 1,069.3 сая төгрөгийн нөөцийн үлдэгдэлтэй байна.


ЕС. ЦААШИД ӨВЧЛӨЛ НЭМЭГДЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ:

Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, цар тахлын голомтонд ажиллаж байгаа мэргэжилтэнүүдийг чадавхижуулах, тандалт судалгааны арга зүйд сургах, дэмжлэг үзүүлэх ажлуудыг зохион байгуулах, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх:

- Тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хомсдол үүсэх
- Эмч, эмнэлгийн ажилчдын хүн хүчний нөөцийн хомсдол үүсэх
- Хамгаалах хувцас, хэрэгсэл хүрэлцэхгүй байх
- Цогцос шатаах стандарт зуух байхгүй
- Өрхийн орлого буурах, ард иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлөх

Хавсралт-1:

ГАНШГААС ХАМГААЛАХ АЙМГИЙН НЭГДСЭН ШУУРХАЙ ШТАБЫН БҮТЭЦ




Хавсралт 2: Завхан аймгийн хэмжээнд нийт 12073 тохиолдол батлагдаж нийт хүн амын 16.5% нь халдвар авсан байна. Батлагдсан тохиолдол 6,7,8,9 10-р сар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-1

д/д	Аймаг	Сум	2021 он										Нийт тоо
			3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	
1	Завхан	Улиастай	4	49	15	218	377	865	2352	1114	234	89	5317
2	Завхан	Алдархаан				38	23	41	83	78	20	6	289
3	Завхан	Асгат						30	10	38	15	1	94
4	Завхан	Баянтэс				20	10	18	108	94	15	13	278
5	Завхан	Баянхайрхан				1	1	12	51	39	0	3	107
6	Завхан	Дөрвөлжин				198	36	67	87	43	61	13	505
7	Завхан	Тосонцэнгэл	3	127	192	59	70	156	364	412	64	12	1459
8	Завхан	Завханмандал		14		3	36	7	68	27	8	0	163
9	Завхан	Идэр					20	37	195	124	26	18	420
10	Завхан	Их-Уул		50	31	20	12	41	202	352	82	6	239
11	Завхан	Нөмрөг		2	3	6	20	20	140	39	8	1	796
12	Завхан	Отгон				21	14	37	87	17			173
13	Завхан	Сантмаргац				6	14	16	81	47	22	0	188
14	Завхан	Сонгино				38	7	5	38	72	11	1	176
15	Завхан	Түдэвтэй				2	38	9	51	25	2	0	127
16	Завхан	Тэс				6	9	16	23	89	40	14	197
17	Завхан	Тэлмэн				32	21	46	96	79	16	24	314
18	Завхан	Ургамал					17	6	145	62	81	2	313
19	Завхан	Цагаанхайрхан				1	0	9	39	19	8	9	85
20	Завхан	Цагаанчулуут				32	18	12	52	21	14	1	150
21	Завхан	Цэцэн-Уул				19	10	11	41	97	6		184
22	Завхан	Шилүүстэй	6				13	33	75	131	14	56	328
23	Завхан	Эрдэнэхайрхан						5	22	40	4	3	74
24	Завхан	Яруу					9	32	39	14	3	0	97
Завхан			13	242	241	720	775	1531	4449	3076	754	272	12073

Хавсралт 3: Өвчлөлийн шинж тэмдгийн бүтэц, эмнэлзүйн байдал

Зураг-1



Хавсралт 4: Ойрын хавьтлын хамаарал

Хүснэгт- 2

д/д	Хамаарал	Ойрын хавьталын тоо	Хувь
1	Гэр бүл	14340	52.00%
2	Найз нөхөд	3761	13.60%
3	Ажлын байр	2690	9.80%
4	Төрөл садан	5442	19.80%
5	Байр	1307	4.70%
Нийт		27540	

Тайлан бичсэн:

Гэрээт ажилтан

Т.Баасанжаргал

Тайлан хянасан:

Аудитын менежер:

Б.Дагвасүрэн

Дарга, тэргүүлэх аудитор

Д.Бат-Ундраа